- ✚ 05 сарын 20-25 өдрүүдэд бороотой байсан тул 2 өнжөөд 1 услах усалгаа хийгдээгүй
- ✚ 05 сарын 27 өдөр 15 1 удаа+ кемпийн дотоод зам усалгаа 1 удаа
- ✚ 05 сарын 29 өдөр 1 удаа 11 цаг орчимд
- ✚ 06 сарын 01, 03-ны өдрүүдэд бороо орсон.
- ✚ 06 сарын 03 нд 11 цаг 40 минутад 1 удаа
- ✚ 06 сарын 05 нд 11 цагт 1 удаа
- ✚ 06 сарын 07 өдөр 12 цаг орчимд 1 удаа+ кемпийн дотоод зам усалгаа 1 удаа
- ✚ 06 сарын 09 өдөр бороотой өдөр байв.
- ✚ 06 сарын 12 өдөр 13 цаг орчимд 1 удаа
- ✚ сарын 14,15 өдөр бага зэргийн бороотой өдөр усалгаа хийгээгүй
- ✚ 06 сарын 17 өдөр 11 цаг орчимд 1 удаа
- ✚ 06 сарын 20-25 өдрүүдэд бороотой байсан тул 2 өнжөөд 1 услах усалгаа хийгдээгүй
- ✚ 06 сарын 27 өдөр 15 1 удаа+ кемпийн дотоод зам усалгаа 1 удаа
- ✚ 06 сарын 29 өдөр 1 удаа 11 цаг орчимд
- ✚ 07 сарын 01-15-ны өдрүүдэд усалгаа хийгдээгүй бороотой байв.
- ✚ 07 сарын 17-нд усалгаа 1 удаа
- ✚ 07 сарын 19-өөс 08 сарын 10 хүртэл зам усалгаа хийгдээгүй бороотой байв.
- ✚ 08 сарын 10, 13, 15 бороотой өдрүүд

Төслийн үйл ажиллагааны явцад усалгааг бороотой өдрөөс бусад өдөрт усалгаа хийсэн бөгөөд бороотой өдөр нэлээд цөөн тоотой байв.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний 4-р заалтын биелэлт



Зураг 7. Уурхайн замын ачааллыг бууруулах, тоосжилтыг багасгах зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Уурхайн замын тоосжилтыг бага байлгаж ачааллыг бууруулах зорилгоор давхацсан тээвэрлэлтийг зогсоож зөрлөгөөс бусад тохиолдолд ачих техник хэрэгсэл 1 замыг ашиглахгүй байхаар тооцож маршрутыг гаргав. Бидний тооцсоноор эхний тээврийн хэрэгсэл явж өнгөрснөөс 1-1.5 минутын дараа тухайн замаар дараагийн машин өнгөрч буй тул тухайн биелэлт бүрэн хангагдсан байна. Мөн уурхайн замаар зорчиж буй нийт тээврийн хэрэгслүүдийн хурдийн ачаатай үед 20 км цагаас бага байхаар тооцож, харин ачаагүй үед 40 км цагаас бага байхаар төлөвлөж нийт жолооч (операторуудад) сануулга зөвлөмжийг өгсөн болно.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний 3 ба 5 дугаар заалтын биелэлт





Зураг 8. Замын тэмдэг тэмдэглэгээ болон хурдны хязгаар заасан тэмдэг, тэмдэглэгээ тавьсан байдал

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний 6, 7 дугаар заалтын биелэлт



Зураг 9. Уурхайд ашиглаж буй техникийн засвар үйлчилгээг хийж буй байдал

Уурхайн байршилд ажиллаж байгаа нийт техник хэрэгслийн засвар үйлчилгээг тогтмол сард 1 удаа, зарим тохиолдол 7 хоног тутамд 1-2 удаа эвдрэл их гардаг техникүүдийн засвар оношлогоог хийж байна. Мөн засах боломжгүй техникийг үйл ажиллагаанаас түр гаргаж сэлбэг хэрэгсэл ирсэний дараагаар засварлаж үйл ажиллагаанд оруулж байна. Мөн өөрсдийн хүч хүрэхгүй мэргэжилийн суурилуулалт тал дээр асуудал гарсан тохиолдолд гаднаас тухайн техникийн сэлбэгийг нийлүүлсэн үйлдвэр, сэлбэг нийлүүлсэн аж ахуй нэгжээс мэргэжилтнүүд ирж суурилуулалт тохиргоог хийж өгдөг болно.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний 8-р заалтын биелэлт Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөр хангагдсан

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний 9-р заалтын биелэлт

Уурхайн буюу лицензийн талбайн гаднах орон нутгийн замтай 200 м зайгаар холбогдож байгаа тул 1 замаар холбогдож нөлөөлөл бага байх бүх боломжоор хангасан. Төслийн талбайн байршилаас орон нутгийн замд шилжих нөхцөлд 1 зам ашиглаж байгаа боловч орон нутгийн зам олон салаа зам байгаа учир хуучны өргөтгөсөн сайжруулсан шороон замаар зорчилт хийж байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний 10-р заалтын биелэлт



Зураг 10. Ахуйн шингэн ба хатуу хог хаягдлыг эко байдлаар шийдвэрлэсэн



Уурхайн ахуйн хатуу хог хаягдал

Уурхайн ажилчдын болон кемпийн байрлалаас гарч буй хатуу хог хаягдлыг ажилчдын амрах байр болон гал тогооны байрлалаас 50-70 зайд байрлуулж сар болгоны эхэнд Булган аймгийн Бүрэгхангай сумын хогийн цэгрүү өөрсдийн тээврийн хэрэгслээр зөөн аваачиж асгаж байна. Мөн ахуйн хог түр хадгалах цэгийн ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг сар болгоны 15-16-ны хооронд хийж тогтмол хэвшил болгон ажиллаж байна.

Уурхайн ахуйн шингэн хаягдал

Уурхайн кемп-д ажиллаж байгаа нийт ажилчдын хэрэглээ болон гал тогооноос гарч буй хаягдлыг цэвэрлэх зорилгоор бага оврын цэвэрлэх байгууламжийг кемпийн байрлалд суурлиулсан бөгөөд тухайн хаягдлыг боловсруулан саарал ус болон гардаг ба саарал усанд ариутгал хийж хөрсөнд шингээх байдлаар шингэн хаягдлыг байгальд ээлтэй байдлаар шийдвэрлэж байна. Тухайн цэвэрлэх байгууламж нь GIZ олон улсын хамтын ажиллагааны сангаас Монгол улсад нэвтрүүлж буй хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээний томоохон төслийн нэг бөгөөд зөвхөн уул уурхайн сууринд тохирсон түр сууршилын бүсийн 100-150 хүний хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг бидэнд хүргэж өгч байгаа юм. Манай уурхайд суурлиулсан энэхүү цэвэрлэх байгууламж нь нэг дор 100-150 хүний хэрэглээнээс гарсан хаягдал усыг цэвэрлэх хүчин чадалтай тул манай уурхайд байрлаж ажиллаж буй 80-90 хүний хэрэглээг хангахад хүчин чадал нь хангалттай хүрэлцээтэй байна.

Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний 11-13-р заалтын биелэлт

Шатах тослох материалыг хадгалж буй газар нь уурхайн нөхцөлд тохирсон стандартын шаардлагад нийцсэн талбай байгаа. Энэ нь кемпийн хамгийн урд зах буюу ажилчдын амрах байр олны хөлөөс зайдуу газар байрлаж байна. Мөн тухайн цэгээс түлшний машин ирж түлш дүүргээд буцаж уурхайн ажлын талбарт очиж бусад техникд түлш дүүргэхдээ түлш дусах цэгийн доор хучаас дэвсэж сөрөг нөлөөллийг бууруулж ажиллаж байна. Мөн авто засварын ажил хийх, тос солих зэрэгт хучаас дэвсэх зэргээр нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч байна.



Зураг 11. Шатахуун асгарч хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний 14-р заалтын биелэлт 24-р заалтын биелэлтээр хангагдсан

Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний 15-р заалтын биелэлт орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтээр хангагдсан

Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний 16-р заалтын биелэлт нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлтээр хангагдсан

Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний 17-р заалтын биелэлт

Уурхайн үйлдвэрлэлд ашиглаж байгаа усыг шүүрлийн усаар хангаж байна. Мөн үйлдвэрлэлд ашиглах усны хэмжээнд Монгол улсын хэрэгжүүлэгч агентлаг болох Усны газар-аас холбогдох баримт бичиг болох Ус ашиглуулах дүгнэлтийг авж, тухайн дүгнэлтэд тулгуурлан Туул голын Сав газрын захиргаатай ус ашиглуулах гэрээг байгуулсан. 2024 оны байдлаар бидний угаан баяжуулах ажилд шаардлагатай ажилд шаардагдах усны хэмжээнд тухайн талбайгаас гарч буй шүүрлийн ус хүрэлцэх байдал дутмаг байсан тул бид бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадалгүй 83 орчим хувийн хүчин чадалтай ажилласан. Энэ нь нэг үгээр бол 5 хоног ажиллаад 1 хоног амрах байдлаар ажиллаж байсан тул энэхүү тооцоолол бий болж байгаа юм.

Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний 18-р заалтын биелэлт

Технологид ашиглаж буй нийт усны хэрэглээний 70-75 орчим хувийг эргүүлэн ашиглах замаар Баяжуулах технологийн усны хэрэглээг хангаж байна. Учир нь тухайн талбайд ашиглаж буй тунгаагуурын нуур болон цэвэр усны нуур нь үндсэндээ 1 цул нуур бөгөөд

тунгаагуурын нуур буюу бохирын нууранд тунаж цэвэршсэн ус цэврийн нуурлуу ус нь сэлбэгдсэнээр эргүүлэн ашиглаж байгаа явдал болж байгаа юм. Энэхүү ус ашиглалтын системийн нуур нь шүүрлийн ус болон карьераас гарч буй усны шавхан зайлуулалтаар тэжээгдэж байгаа тул бидний технологид 83% хүрэлцээтэй байж чадсан болно.

Тунгаагуурын буюу Бохирын нуур



Цэвэр усны нуур



Зураг 12. Технологийн нуурууд

Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний 19, 20-р заалтын биелэлт

Ажилчдын унд ахуйд ашиглах усны эх үүсвэр болох гүний худгийн усны зөвшөөрлийг Туул голын сав газрын захиргаанаас авсан. Учир нь уул уурхайд ажиллаж буй нийт ажилчдын хэрэглээг хангаж буй тул Усны тухай хуульд заасанчлан Сав газрын захиргаанаас 2022.09.28 өдрийн 04/637 тоот зөвшөөрлийг авж гүний худаг гаргасан болно.

Мөн гүний худгийг гаргах үедээ гүний өрөмдлөгийн тусгай зөвшөөрөлтэй “Ус Баясгалан” ХХК-аар гаргуулж худгийн паспортыг баталгаажуулсан.

Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний 21, 22, 23-р заалтын биелэлт

Уурхайн ажилчдын унд ахуйн худгийн усны тоолуурыг баталгаатай хэмжил зүйн лабораториор баталгаажсан усны тоолуурыг худалдан авч уурхайн байршилд суйрлуулсан болно. Мөн худгийн байршилд ямар нэгэн бохир оруулахгүй, гадны нөлөөллөөс хамгаалах зорилгоор кемпийн төв барилгын дотор сайтар хамгаалалт хийж хамгаалсан болно. Худгийн усны тоолуурыг Булган аймгийн Бүрэгхангай сумын Байгаль орчны улсын байцаагч ирж баталгаажуулж лацадсан



Зураг 13. Худгийн усны тоолуурыг суурьлуулсан байдал

Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний 24, 25-р заалтын биелэлт

Манай уурхайн үйл ажиллагаа явуулж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн зах нь Туул голын эргийн бүсээс 200 м зайд байрлах тул голын эрэг орчимд үйл ажиллагаа явуулахгүй. Мөн тусгай зөвшөөрлийн талбай дотроо кемп болон хогийн цэгүүд байрлаж байгаа тул Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний 25-р заалтын биелэлт бүрэн хангагдсан.

Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний 26-р заалтын биелэлт

Бид анхан шатны төлөвлөлт хийх, уурхайн олборлолтын ажил эхлэхийн өмнөх шатанд нийт ажилчдад анхааруулга санамжийг хүргэж гол бохирдуулахгүй байх, хамгаалалтын бүсийн дэглэм гэж юу байдаг талаар зөвлөмж боловруулж ажилласан.

Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний 27-р заалтын биелэлт

Машин техникийн аюулгүй ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг хангах, шаардлагатай үед засвар үйлчилгээг зориулалтын засварын газарт хийлгэх, шатах тослох материал алдагдсан бол нэн даруй элс, даавуунд шингээн авах эсвэл бохирдсон хөрс шороог гүн рүү нэвчихээс өмнө хүрээр хусаж авах гэсэн заалтын дагуу элс болон арчих материал зэргийг уурхайн контейнорт хадгалж авсан. Мөн 2024 оны уурхайн авто засварын талбай буюу тос солих талбайг аюултай хаягдлын байртай хамт шийдэж өгснөөр нөлөөллийг улам бууруулж чадсан. Мөн өмнө нь ил задгай цементлэсэн талбайд засварын ажил явуулдаг байсан бол энэ онд өөрийн засвар үйлчилгээ хийх байрыг шийдвэрлэж өгсөн нь нөлөөлөл үүсэх талбайг хумисан том ажил болоод байгаа юм.



Зураг 14. Засвар үйлчилгээ хийх зориулалттай 8x12м хэмжээтэй талбай болон дугуйн талбай, мөн хаягдал тос хадгалах аюултай хог хаягдлын талбай

Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний 28-р заалтын биелэлт



Зураг 15. Уурхайн хотхоны зохион байгуулалт

Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний 29-р заалтын биелэлт

Уурхайн ээлж солих үед зорчдог орон нутгийн замаас өөр зам ашигладаггүй ба уурхайн дотоод тээврийн замаас өөрөөр орон нутгийн замыг ашиглах шаардлага гардаггүй.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний 30-32-р заалтын биелэлт

Уурхайн орчимд зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнтэй таарвал үргээлгүй зам тавьж өгөн өнгөрөөж байх;

Бэртэж гэмтсэн, аюулд орсон зэрлэг ан амьтантай таарвал орон нутгийн байгаль хамгаалагчид мэдэгдэж шуурхай арга хэмжээ авах

Төслийн ажилчдад хууль бус ан агнуур хийхгүй байх, худалдаалахгүй байх талаар анхааруулга өгч, хяналт тавьж ажиллах

Гэсэн дээрх заалтын биелэлтийг ханган ажиллаж байна. Мөн уурхайн ажлын цагийн хувиар шахуу байдаг тул хулгайн ангийн тохиолдол гарахгүй ба уурхайн дуу чимээ их тул зэрлэг амьтан төдийлөн уурхайн бүсэд нэвтэрдэггүй.

Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний нийгэм эдийн засгийн хэсэг 33-37-р заалтуудын биелэлт

Төслийн үйл ажиллагаанд орон нутгийн ажилгүй иргэдийг оролцуулж, иргэдийг ажлын байраар хангах:

Уурхайд ажиллах сонирхолтой нутгийн иргэдийг сул ажлын байрны орон тоонд бүртгэн уурхайд ростероор ажиллуулах явц 2024 оны байдлаар орон нутгаас нийт хүн ажилд орсноос иргэн ажиллаж, иргэн ажлаасаа гарсан.

Ажилчдын хүнсэнд хэрэглэх мах, сүү, ногооны хэрэглээг орон нутгийн малчид тариаланчидтай гэрээ байгуулж хангах:

Ажилчдын хүнсэнд хэрэглэж буй махыг Булган аймгийн Бүрэгхангай сумын Дэрст багийн иргэдээс авч хүнсэнд хэрэглэж байна. Харин багийн иргэдээс хүнсний ногоо нийлүүлэх айл байхгүй байгаа тул бид уурхайн хүнсэнд ашиглах ногоог Улаанбаатар хотоос авч уурхай руу тээвэрлэж байна.

Орон нутгийн худалдаа үйлчилгээ эрхэлж буй иргэдийн үйл ажиллагааг дэмжиж шаардлагатай бараа материалын татан авалтыг сум орон нутгаас хангахыг зорих

Сумын иргэдийн эрхэлж буй худалдаа үйлчилгээ нь бидний үйл ажиллагаанд шаардлагатай бараа материал тун цөөн тул Улаанбаатар хотоос өөрсдийн хэрэгцээт бараа материалыг татаж байна. Хэрэв бидэнд шаардлагатай авто машины сэлбэг болон бусад эд зүйлс, Бүрэгхангай сумаас зах зээлийн үнэд нийцүүлэн нийлүүлэх санал ирвэл бидэнд татгалзах зүйлгүй хүлээн авна.

Төсөл хэрэгжүүлэгч нь харьяа сумтайгаа орон нутгийн хөгжлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх гэрээг байгуулсан.

3.4. Уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө ба түүний биелэлт

Төслийн үйл ажиллагаанд 2024 оны байдлаар техникийн болон биологийн нөхөн сэргээлт тусгагдаагүй болно. Ирэх жил буюу 2025 онд багтаан төслийн нийт талбайд техник болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэх ба үүний дараагийн шатанд уурхайн хаалтын төлөвлөгөө болон хаалтын журмаар хийгдэх бүхий л ажилбарууд хийгдэх юм.

3.5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө ба түүний биелэлт


Дүйцүүлэн хамгааллыг тооцоолох программд суурилан нөлөөлөлд өртөх талбай, дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээ болон байршил, зардлыг тооцоолж БОННУ-ний 4.9-р бүлэгт тусгасан. Үүнд үндэслэн төслийн биологийн олон янз байдал, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж дараах харуулав.

Хүснэгт 9. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Хууль бус алт олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх	Багийн иргэдийн нийтийн хуралдаан болон Булган аймгийн байгаль орчны газар, Бүрэгхангай сумын байгаль хамгаалагч нартай зөвшилцсөний дагуу техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэлдүүлэх	Лицензийн талбайн зүүн урд талд эвдрэлд орж орхигдсон газар	5 га		17,810,000	2024	БОНБУ-ний тухай хуулийн 3.1.11, 9.6. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд бид 2024 онд Туул голын эрэг дагуу бичил уурхайн олборлолтын нөлөөллөөр эвдрэлд орсон 5 га талбайтай газарт техникийн нөхөн сэргээхээр төлөвлөсөн ба тус ажлыг 2024 оны 10-р

сарын 15-ны өдрөөс 11-р сарын 19-ний өдрийг хүртэл гүйцэтгэсэн. Тус ажилд 1 бульдозер, 2 экскаватор, 4 дамп, 16 ажилтан, 20 цаг буюу 2 ээлжээр ажиллав.



Таних тэмдэг

● Эргэлт цэг

ӨМНӨ НЬ


нэр

□ Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний талбай 2024

□ Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний талбай 2023

□ "Мөнх нархан орд" ХХК лицензийн талбай

Зураг 16. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн байршил (Өмнө нь)



Зураг 17. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн байршил (Одоо)



Зураг 18. Техникийн нөхөн сэргээлт хийж байх үеийн зураг



Зураг 19. Техникийн нөхөн сэргээлт хийсний дараах

3.6. ТЭРБУМ МОД үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажил ба түүний биелэлт

Мод, сөөг тарихдаа тухайн байгалийн бүс, бүслүүрийн онцлогт тохирсон модны төрөл зүйлийг сонгох, Монгол улсын холбогдох стандартартуудыг (MNS 6140:2010 Мод, сөөгний тарьц. Техникийн шаардлага, MNS 6253-1:2011 Мод, сөөгний үрийг тарихад бэлтгэх. Ерөнхий шаардлага, MNS 6253-2:2011 Мод, сөөгний үрийг тарих. Ерөнхий шаардлага, MNS 6253-3:2011 Мод, сөөгний үрийг тарьсны дараа арчлах.

Ерөнхий шаардлага, MNS 2418:2011 Мод үржүүлгийн газрын хөрсийг боловсруулах, MNS 6252:2011 Мод үржүүлгийн газар бордоо хэрэглэх, MNS 6254:2011 Мод, сөөгний суулгацыг бойжуулах. Ерөнхий шаардлага, MNS 6258-1:2011 Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах. Ерөнхий шаардлага, MNS 6139: 2010 Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага, MNS 6141:2010 Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага, MNS 5918:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага гэх мэт) баримтлан тарилт, үржүүлэг хийх.



Зураг 20. Мод тарих ажлын 1-р шат худалдан авч, ачиж ирэх

2024 оны мод тарих өдрөөр бид мод үрсэлгээний газраас худалдан авсан сибирь улиас болон бургас гэсэн 2 төрлийн 1,000 ш модыг шууд өөрсдийн техникээр ачиж мод тарих газраа авчирсан. Мод ачсан машин очихоос өмнө мод тарих талбай дээр бусад ажилчид маань авчирсан суулгацыг шууд суулгах нүх болон бордоо, хөх бууцыг бэлдэж хөрснөөс салгаж дараагийн хөрсөн үрсэлгээг шилжүүлэх хугацааг бага байлгах, улмаар мод ургах боломжийг улам нэмэх зорилготойгоор ажилласан.

Суулгацыг шилжүүлэн суулгах талбайг бэлдэхдээ бид 1 экскаватор 2 оператор, 1 чиглүүлэгч гэсэн бүрэлдхүүнтэй ажиллаж шуудуулах маягтай ухаш бэлдсэн ба тухайн шуудуулж татсан ухашд модыг суулгахдаа 50см х 50см гэсэн байдлаар нүх ухаж бэлтгэн модыг суулгасан. Тус ажлыг гүйцэтгэхдээ нүх болгоны хажууд сайжруулж бордоотой хольсон хөрс болон хөх бууцыг бэлдэж тавьсан нь мод ургах орчин нөхцөлөөр хангахад нь туслах зорилготой юм.




Зураг 21. Модны нүхийг бэлдэж буй байдал





Зураг 22. Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод суулгаж буй байдал
Нийт 15 хүний бүрэлдхүүнтэй мод тарих ажил хийгдсэн ба 500 ш сибирь улиас, 500ш бургас нийт 1,000 ш модыг тарьсан болно.



Legend

- биологийн олон үнэ байдлиг дуйтсвulen хамгаалах талбай
- Мод тарих талбай

Мод хоорондын зай- 3м
Эгнээ хоорондын мөрний зай- 5м
Эгнээний нийт урт- 180 м
Нийт мөрний зай буюу эгнээнүүдийн нийт урт- 80 м
Нэг эгнээнд байх модны тоо- 60-61 ш мод
Нийт эгнээний тоо- 17

Зураг 23. Мод тарьсан талбайн байршил

3.7. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө ба түүний биелэлт

Хүснэгт 10. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
Байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх								
1	Машин механизм, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал алдагдсанаас осол аваар гарах эрсдэлтэй.	Уурхайн үйл ажиллагаанд ашиглах машин механизм, техник тоног төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг бүрэн хангасан байх	Уурхайд ажиллаж буй өөрөө явагч тоног төхөөрөмж болон хүнд даацын техник хэрэгсэл, скрубер	Ашиглах тоног төхөөрөмжийн тоогоор	Механикчийн цалингийн зардлаар	2024		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS 4968 : 2000
2		Хэрэв төслийн талбай дээр машин механизм, тээврийн хэрэгсэл эвдэрсэн бол засварын газарт шаардлагатай бүх засвар үйлчилгээг хийсний дараа үйл ажиллагаа явуулах						Механикчийн цалингийн зардлаар
3	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангаагүй эсвэл хэрэглээгүй, ХАБЭА-н дүрэм зөрчигдсөн үед болзошгүй осол аваарт өртөх	Бүх ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж, хэрэглүүлж хэвшүүлэх	Уурхайн ажилчид, албан хаагчдад	Нийт ажилчдад	Дотоод зардалаар			Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Хамгаалалтын хувцас - Ерөнхий шаардлага MNS ISO 13688 : 2000
4		Бүх ажилчдад ХАБЭА-н зааварчилгаа өгч гарын үсэг зуруулах, ХАБЭА-н зааварчилгаанд хамрагдаагүй ажилчдыг төслийн талбай дээр ажиллахыг хориглох, үүнд	Ажилчид ажилд гарахын өмнө	Нийт ажилчдад	Дотоод төлөвлөлтийн болон ХАБЭА-ийн зардлаар			Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		ХАБЭА-н ажилтан байнга хяналт тавьж хариуцлагатай ажиллах						MNS 4968 : 2000
5	Ослын нөхцөл хүндрэх	Ажилчдад анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийг байнга бэлэн байлгах	Төслийн ажилчдын эрүүл ахуй	Багц	1,000,000			Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он
6		Төслийн талбайн орчимд анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, санамж байрлуулах, хязгаарлалтын бүс тогтоох	Төслийн үйл ажиллагаа явуулах талбайд	20	Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний зардалд тусгасан		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он	
7	Болзошгүй аюул ослын улмаас гал гарах	Галын аюулгүй байдлыг хангаж, гал унтраах анхан шатны болон суурин тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийг байршуулах, галын хор цэнэгтэй эсэхийг байнга шалгаж, цэнэг нь дууссан бол цэнэглүүлж байх	Төслийн үйл ажиллагаа явуулж буй талбай болон төслийн үйл ажиллагааны хүрээнд	3	500,000			Галын аюулгүй байдлын тухай хууль, 2015 он Хөдөлмөр хамгаалалын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS 4244 : 1994 Галын аюулаас хамгаалах нийтлэг асуудал. Галын ангилал MNS 4284:2017
8	Байгаль, цаг уурын гэнэтийн аюултай үзэгдлийн улмаас осол гарах	Цаг агаарын аюулт үзэгдэл болж болзошгүй сэрэмжлүүлэг зарласан өдрүүдэд бүх ажилчдад дуулган, сонор сэрэмжтэй ажиллахыг сануулах, аян замд гарахгүй байх, төслийн үйл ажиллагаанд хязгаарлалт хийх, онцгой тохиолдолд ажиллуулахгүй байх арга хэмжээ авах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд			Дотоод төлөвлөлтийн болон ХАБЭА-ийн зардлаар		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он
9	Тээвэрлэлтийн зам	Шороон шуургатай өдрүүдэд	Төслийн үйл			Дотоод		

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	үзэгдэх орчин муудсанаас осол гарах	тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурдад хязгаарлалт хийх, сонор сэрэмжлүүлгийг өндөржүүлэн ажиллах	ажиллагааны хүрээнд		төлөвлөлтийн болон ХАБЭА-ийн зардлаар			
Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний					1,500,000			

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний 1-2 дугаар заалтын биелэлт сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний 6-7 дугаар заалтын биелэлтээр бүрэн хангагдсан.

Уурхайн байршилд ажиллаж байгаа нийт техник хэрэгслийн засвар үйлчилгээг тогтмол сард 1 удаа, зарим тохиолдол 7 хоног тутамд 1-2 удаа эвдрэл их гардаг техникүүдийн засвар оношлогоог хийж байна. Мөн засах боломжгүй техникийг үйл ажиллагаанаас түр гаргаж сэлбэг хэрэгсэл ирсэний дараагаар засварлаж үйл ажиллагаанд оруулж байна.

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний 3-р заалтын биелэлт



Зураг 24. Нийт ажилчдад өвөл болон зуны хувцасны хангалт бэлдсэн байдал


Уурхайн нийт ажилчдыг хөдөлмөр хангаалалын хувцас хэрэглэлээр бүрэн хангасан ба хүн нэг бүрийн хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр нийт ажилчдыг хангасан бөгөөд төслийн үйл ажиллагаанд бороотой нөхцөл байдал үүсэх тохиолдолд /гадаа ажиллах нөхцөлд/ бүх ажилчдад өмсгөх хэмжээний нөөц цуврыг бэлдсэн байгаа.

- Каск
- Тоос, нарнаас хамгаалсан маск
- Нимгэн болон зузаан куртик
- Өмд
- Safety тэй гутал
- Гагнуурчинд зориулсан каск
- Гадны зочидод өмсгөх каск, хантааз зэрэг болно.

Уурхайд шинээр ажилд орох хүн ирсэн тохиолдолд хамгийн эхэнд тухайн ажилтанд ХАБЭА-ийн дүрэм журамтай танилцуулсны дараагаар ээлжийн ажлын хугацаанд амьдрах орон байрыг нь танилцуулан дараагаар нь ажиллах орчин нөхцөлд тохирсон хувцас хэрэглэлээр хангадаг. Энэхүү хувцас хэрэглэл нь 20-оос дээш тооны ажилтан солигдох, эсвэл нэмж ажилчин авсан тохиолдолд хангалттай хүрэлцхүйц тоогоор уурхайн кемпийн байршилд одоогоор байна. Гол зорилго нь өмнөх ажилчны эдэлж хэрэглэж байсан элэгдэж хуучирсан хувцас хэрэглэлийг шинээр ажилд орогсгод өмсгөхгүй байх нь хөдөлмөр хамгааллын хувьд давуу байдлыг олгоно гэж үзсэн тул хувцасны хангалтыг хангалттай хэмжээгээр нөөцөлсөн болно.

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний 4-р заалтын биелэлт

Бүх ажилчдад ХАБЭА-н зааварчилгаа өгч гарын үсэг зуруулж өдөр тутам арга хэмжээг авч байгаа. Мөн ХАБЭА-н зааварчилгаанд хамрагдаагүй ажилчдыг төслийн талбай дээр ажиллахыг хориглох арга хэмжээг авч байгаа ба ажилчид ажилд гарахаас өмнөх ХАБЭА-ийн бүртгэлийн дэвтэрт гарын үсэг зурснаар ажилсан цагийн хөлс тухайн бүртгэл дээрээс харж бодогддог болсноос хойш гарын үсэг зурахгүй үлдэх тохиолдол гарахгүй байгаа. Үүнд ХАБЭА-н ажилтан байнга хяналт тавьж ажиллаж байна.



Зураг 25. ХАБЭА-ийн зааварчилгааний бүртгэл хөтөлж буй зураглал ба ХАБЭА-ийн зааварчилаанд гарын үсэг зурсан байдал
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний 5-р заалтын биелэлт

Уурхайн үйл ажиллагаа явуулах үеийн бүхий л үйл ажиллагаанд яаралтай үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний эхний заалтуудын нэг болох аливаа эрсдэл гарах үед болон ажилчидын бие өвдөх тохиолдолд эмнэх зорилготойгоор уурхайд эмний хангалт, дусал, бүх төрлийн өвчний эсрэг эм, зэргээр хангадаг бөгөөд уурхайн 1 эмч байрлаж ажилладаг бөгөөд 14/14 ростероор

ээлжийн ажилтан 2 эмчийг ажлын байраар хангаад байна. Тухайн эмч нь уурхай дээр байгаа нийт ажилчдын эрүүл мэндийн байдалтай танилцах, ярилцах, зөвлөгөө өгөх, эм бичиж өгөх, бүх ажилчдын эрүүл мэндийн байдалд хяналт тавих зэрэг ажлыг хийж байна.



Зураг 26. Эмчийг ажлын багаж хэрэгсэл ба эм тариагаар хангасан байдал



Зураг 27. Эмч болон ХАБЭА-ийн ажилтны эрүүл аюулгүй ажлын байрны талаар сургалт зохион байгуулсан

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний 6-р заалтын биелэлт сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний 3-5 дугаар заалтуудын биелэлтээр бүрэн хангагдсан

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний 7-р заалтын биелэлт

Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллаж байгаа бөгөөд нийт 3 газарт галын хор, галаас хамгаалах багаж хэрэгсэлийг байрлуулсан байгаа мөн галын сарааг тохижуулсан. Мөн галын хорыг ажилчдын амрах байрны 2 байшин дунд ш галын хор, уурхайн оффисд 1 ш, гал тогоонд 2 ш, агуулахад 2 ш, галын хорны нөөцөд 2022 оны 08 сарын 1-ний өдөр 5 ш нөөцөнд авсан байна.

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний 8-9 дүгээр заалтын биелэлт

Цаг агаарын аюулт үзэгдэл болж болзошгүй сэрэмжлүүлэг зарласан өдрүүдэд бүх ажилчдад дуулган, сонор сэрэмжтэй ажиллахыг сануулах, аян замд гарахгүй байх, төслийн үйл ажиллагаанд хязгаарлалт хийх, онцгой тохиолдолд ажиллуулахгүй байх арга хэмжээ авах гэсэн заалтын дагуу дараах арга хэмжээг авч ажиллаж байна.

Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан цаг агаарын мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглаж хэвшил болгож ажиллаж байна. Цаг агаарын мэдээг авахдаа <http://w.tsag-agaar.gov.mn/forecast/forecast5days> сайтыг ашиглан ойрын 5 хоногийн цаг агаарын мэдээг 3 өдөр тутам уурхайн дарга, ХАБЭА-ийн ажилтан авч ажилчдад зөвлөмж өгөх, бороотой өдөр цув өгөх, халуун өдөрт уух цай, усыг бэлдүүлэх зэргээр ажилчдын ажиллах орчин нөхцөлийг ханган ажиллаж байна.



Зураг 28. Цаг агаарын мэдээг харах байдал

Дээрх аргачлалаар цаг агаарын мэдээг авахад хялбар байдаг бөгөөд эхлээд аймгийн нэрийг сонгон, дараагаар сумын нэрийг газрын зураг дээрээс сонгоход тухайн сумын цаг агаарын харуулын цэгээс өгсөн 5 өдрийн цаг агаарын мэдээ гарч ирэх байдлаар ашиглагдана.

3.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө ба түүний биелэлт

Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө ба түүний төлөвлөгөөт зардал

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1		2	3	4	5	6	7	8	9
Ахуйн хатуу хог хаягдал									
1	Хатуу хаягдлаар орчныг бохирдуулах	Дахин боловсруулах болон дахин боловсруулах боломжгүй хаягдлыг орон нутгийн захиргаанаас зааж өгсөн төвлөрсөн хаягдлын цэг рүү тээвэрлэх	Уурхайгаас-сумын хогийн цэг	Сар бүр		400.0		2024	Хог хаягдлын тухай хууль, 2017 он
Аюултай хог хаягдал									
2	Моторын ажилласан тосыг удаан хугацаанд хадгалснаас болж савны элэгдэл үүсч асгарах хөрсний бохирдолт үүсгэх	Аюултай хаягдлуудыг тусгай зориулалтын талбайд түр хуримтлуулан дахин боловсруулах үйлдвэрүүд рүү нийлүүлэх арга хэмжээ авах	Төслийн үйл ажиллагааны явцад	Төслийн үйл ажиллагаа явуулах шатанд		500,000		2024	Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоход тавигдахшаардлага болон зөвшөөрөл олгох журам
3		Дахин боловсруулах үйлдвэртэй гэрээ байгуулж ажиллах ба нийлүүлсэн хаягдлын бүртгэлийг тогтмол хөтлөх	Төслийн үйл ажиллагаа явуулах бүхий л хугацаанд	-	-	-	-	2024	

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Бусад хог хаягдал									
4	Нэг удаагийн ахуйн хэрэглээ нь ахуйн хог хаягдлыг хэмжээг ихээр нэмэгдүүлнэ.	Нэг удаагийн ахуйн хэрэглээнээс тагталзах буюу нэг удаагийн аяга таваг болон бусад зүйлсийг огт хэрэглэхгүй байх, ахуйн хэрэглээний материалыг аль болох олон удаа ашиглах байдлаар үүсэж болох хаягдлыг бууруулах	Төслийн үйл ажиллагаа явуулах бүхий л хугацаанд	-	-	-	-	2024	-
5	Хаягдлын цэгүүдийн орчмын хөрс бохирдох, хөрсний ус, хур тунадасны угаагдлаар дамжин гадаргын болон газрын доорх ус бохирдох	Хаягдлын цэгүүдийн орчимд хөрсний мониторингийн цэг байгуулж хог хаягдлын улмаас хөрс нян болон хүнд металаар бохирдож буй эсэхийг тогтмол хянах, мониторингийн хяналтын үр дүнг ТЖБОМТ, түүний биелэлтийн тайланд тусгаж байх	Уурхайн кемпийн ахуйн жорлон ба хогийн цэгийн орчимд	Тоо	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт зардлыг тусгав.			2024	Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 : 2019
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө						900,000			

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний 1-3 дугаар заалтын биелэлт- Энгийн хог хаягдал



Зураг 29. Ахуйн хог хаягдлыг цэгийг барьсан байдал

Дээрх зураглалд харагдаж буй хогийн цэгийг бид хийхдээ 3 төрлөөр ангилан ялгах боломжтой хогийн цэг болгон шийдвэрлэж дахин боловсруулах боломжтой хог хаягдал гарсан тохиолдолд Улаанбаатар хотруу дахин боловсруулах боломжтой хоёрдогч түүхий эд авдаг иргэнд өгч байна. Мөн дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг Бүрэгхангай сумын төв хогийн цэг өөрийн тээврийн хэрэгсэлээр хүргэж төвлөрүүлж байна. Мөн хогийн цэгийн кемп байрлаж буй талбайн байршилаас 150 м орчим зайд байрлуулсан ба энэ нь салхины чигийн доор байрлаж байна. Мөн нэг удаагийн хэрэглээний эд зүйлсийг аль болох худалдан авахгүй байгаа. Энэ нь энгийн хог хаягдлыг бага хэмжээтэй байхад үр дүнтэй арга хэмжээ болж байна. Мөн жорлон болон ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж, хогийн цэгт тогтмол халдваргүйжүүлэлтийн ажлыг гүйцэтгэж байна.



Зураг 30. Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажил



Зураг 31. Хог ачилт ба халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний 4-6 дугаар заалтын биелэлт- аюултай хог хаягдал

Уурхай ажиллаж байх хугацаанд гарсан аюултай хог хаягдлыг хадгалах зориулалтын талбайг засаж тохижуулсан ба аюултай хог хаягдал асгарсан тохиолдолд доош хөрсөнд нэвчүүлэхгүй байх зорилгоор шал хэсгийг нь хатуу хучилттай болгон засаж тохижуулсан. Мөн аюултай хог хаягдал (Хаягдал моторын тос) хадгалах, устгах, дахин боловсруулах тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж болох “Хай би Ойл” ХХК-тай манай олборлолтын үйл ажиллагааны туслан гүйцэтгэгчээр ажиллаж буй “Уулс ноён” ХХК гэрээ байгуулан өөрийн тээврийн хэрэгсэлээр зөөж төвлөрүүлж байна.



Зураг 32. Аюултай хог хаягдал хадгалах талбай

Аюултай хог хаягдлыг тээвэрлэхдээ бид өөрсдийн тээврийн хэрэгсэлийг ашиглан 2024 онд 2 удаа хаягдал тос тушаасан байна. Эхний удаа 05 сарын сарын 11-ны өдөр 1.2 тн хаягдал тос, 2 дох удаагаа 09 сарын 19 өдөр 2.6 тн хаягдал тос тус тус тос боловсруулах дээр үйлдвэрлүү тээвэрлэсэн байна.



Зураг 33. Хаягдал тос ачиж дахин боловсруулах үйлдвэрт тушаасан баримт

3.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ба түүний биелэлт

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, байгаль орчны асуудал хариуцсан алба хаагчтай байх ба үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ. Мөн төслийн удирдлагын хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлж түүний төлөвлөлтийг тусгав.

Хүснэгт 12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хувиар			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			Сар ...	Сар ...	Сар ...		
	1	2	3	4	5	6	7
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажилчтантай байх	Цалингийн зардлаар тооцох	Уурхай эхлэхээс өмнө			Захирал ба хүний нөөц	Байгаль орчны үнэлгээний тухай хуулийн (14.1) хэрэгжилт хангагдана

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хувиар			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			Сар ...	Сар ...	Сар ...		
2	Төслийн үйл ажиллагаанд орон нутгийн ажилгүй иргэдийг оролцуулж, иргэдийг уурхайн сул орон тоон дээр ажлын байраар хангах	Дотоод зардал	Ажлын байранд сул орон тоо үүссэн тохиолдолд			ХАБЭА болон БОМэргэжилтэн	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн (101 зүйл) хэрэгжилтийг хангана
3	Ажилчдын хүнсэнд хэрэглэх мах, сүү, ногооны хэрэглээг орон нутгийн малчид тариаланчидаас худалдан авах боломжийг эрэлхийлэх	ХАБЭА-ын зардлаар тооцно	Уурхай үйл ажиллагаа явуулж байх хугацаанд			ХАБЭА	Хог хаягдлын тухай хуулийн (9.2.2-9.2.9 дэх зүйлийн) хэрэгжилтийг хангана
4	Байгаль хамгаалах чиглэлээр хийж, хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээг орон нутгийн иргэд, төрийн захиргааны байгууллагад танилцуулж хэлэлцүүлэг явуулах, тэдний санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх	Гэрээний үнийн дүнгээр тооцно	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулагдаж дуусмагц			Байгууллагын удирдлагууд	Болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлнэ
5	Ажилчидыг уурхайн ажил эхлэхээс өмнө эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Усны эрүүл ахуйн шинжилгээг хийлгэх,	2024 оны 03 сард			ХАБЭА Шинжилгээ авах тохиолдолд БОМ	Ажиллагсадын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлнэ.
6	Төсөл хэрэгжүүлэгч нь орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээг байгуулах	Гэрээнд заасан үнийн дүн, эсвэл гарсан төлбөрийн хэмжээгээр тооцно.	Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө буюу төслийн эхэнд			Удирдлагуудын түвшинд	Төслийн үйл ажиллагаа хэрэгжихтэй холбоотой гэрээ хийгдэнэ.
7	Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг холбогдох дүрэм журам, стандартын дагуу хийж байгалийн унаган	Байгууллагын дотоод зардалаар	2024 онд багтаана.			Удирдлагууд болон БО Мэргэжилтэн, ХАБЭА	Байгаль орчны үнэлгээний тухай хуулийн (14.1.2) хэрэгжилт хангагдана

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хувиар			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			Сар ...	Сар ...	Сар ...		
	төрхөнд оруулан орон нутагт хүлээлгэн өгөх						
8	Үйл ажиллагаа явуулж буй тухайн талбайдаа байгаль орчны хувиарт аудитыг хийлгэх	Урьдчилан авсан үнийн саналаар	2024 онд багтаана.			Удирдлагуудын түвшинд	Байгаль орчны үнэлгээний тухай хууль
Нийт зардал		-	-			-	-

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний 1-р заалтын биелэлт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажилтантай болсон бөгөөд энэхүү ажилтан нь өмнө нь байгаль орчны үнэлгээний компанид 5 жил ажиллаж байсан туршлагатай ажилтан. Тус ажилтны мэдээллийг хавсралтаар орууллаа.

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний 2-р заалтын биелэлт

Төслийн үйл ажиллагаанд уурхайд нийт орон нутгаас ажилд орохыг хүссэн хүн байгаагүй. Харин Булган аймгаас нийт 3 хүн бүртгүүлсэнээс 3 иргэн одоог хүртэл ажиллаж байна.

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний 3-р заалтын биелэлт

Ажилчдын хүнсэн хэрэглэж буй махыг Булган аймгийн Бүрэгхангай сумын Дэрст багийн иргэдээс авч хүнсэнд хэрэглэж байна. Харин багийн иргэдээс хүнсний ногоо нийлүүлэх айл байхгүй байгаа тул бид уурхайн хүнсэнд ашиглах ногоог Улаанбаатар хотоос авч уурхай руу тээвэрлэж байна.

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний 4-р заалтын биелэлт

Байгаль хамгаалах чиглэлээр хийж, хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээг орон нутгийн иргэд, төрийн захиргааны байгууллагад танилцуулж хэлэлцүүлэг явуулах, тэдний санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн .

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авч байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдах биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах газрын байршил болон га талбайн хэмжээг тогтоолгосон. Харин иргэдийн саналыг авахад Туул гол дагасан талбайд техникийн нөхөн сэргээлт хийх санал орж ирсэн тул тухайн талбайг 2024 оны 11 сарын 4-ний өдрийг хүртэл тэгшилж одоогоор 6.98 га талбайг төлөвлөгөөнд тусгасны дагуу нөхөн дүүргэлт тэгшилгээний ажлыг хийж гүйцэтгээд байна.

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний 5-р заалтын биелэлт

Уурхай эхлэхийн өмнө уурхайд ростериор ажиллах бүх ажилчдыг эмчийн бүтэн биений үзлэг, оношлогоонд оруулж, эрүүл мэндийн шинжилгээнд хамруулсан үзлэгт бүрэн хамруулсан.

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний 6-р заалтын биелэлт-Төсөл хэрэгжүүлэгч нь орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээг байгуулсан

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний 7-р заалтын биелэлт-нөхөн сэргээлтийг хүлээлгэн өгсөн

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний 8-р заалтын биелэлт- Гэрээгээр зохицуулагдсан

3.10. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө ба түүний биелэлт

Хүснэгт 13. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Булган аймгийн Бүрэгхангай сумын орон нутгийн нөлөөллийн бүсэл байрлаж буй иргэд, Засаг дарга, иргэдийн хурлын төлөөлөгч	ИТХ хэлэлцүүлэг, илтгэл, нөлөөллийн бүсийн иргэдтэй хийсэн уулзалт	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн талаар танилцуулж санал авах	9-р сард	Байгууллагын дотоод зардал	Удирдлагууд болон БОМЭргэжилтэн	Бүрэгхангай сум
2	Булган аймгийн Засаг даргын 2020 оны А/500 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэгт	Илтгэл, тайлан	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнүүлэх	10-р сард	Байгууллагын дотоод зардал	Удирдлагууд болон БОМЭргэжилтэн	Булган аймаг, Бүрэгхангай сум
3	БОАЖЯ	БОМТ 2022-ийн биелэлтийн тайлан биелэлтийн тайлан	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнүүлэх, батлуулах	12-р сард	Байгууллагын дотоод зардал	Удирдлагууд болон БОМЭргэжилтэн	БОАЖЯ

3.11. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) ба түүний биелэлт

Хүснэгт 14. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	8
Агаарын чанарын бохирдлыг хянах								
1	Хорт хий, бохирдуулагч, дуу чимээний түвшин: <ul style="list-style-type: none"> Тоос /TSP, PM10, PM2.5/ CO2 SO2 NO2 Дуу шуугиан 	Уурхайгаас салхины чигийн дагуу 100 м, 500 м, 1.5 км-т	Жилд 2 удаа 24 цагийн дундаж хэмжилт хийх (нэг хоногт 2 хэмжилт хийх)	2	50,000	100,000	Уурхайн бохирдол ба түүнтэй ойр зэргэлдээх бохирдлын түвшинг хянах	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага /MNS 5885 : 2008/ Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016
2		Ажилчдын хотхоны ойролцоо		2	50,000	100,000		
3		Угаан баяжуулах цехийн орчим		2	50,000	100,000		
Усны чанарын бохирдлыг хянах								
1	Усны ерөнхий үзүүлэлт: рН, Температур, өнгө, хатуулаг, биологийн болон химийн хэрэгцээт хүчил төрөгч, гадаргуугын идэвхит бодис ууссан хүчилтөрөг, анионууд, катионууд, болон эрүүл ахуйн шинжилгээн	Уурхайн ундны ус	2022 8 сар	2	45,000	180,000	Усны ерөнхий химийн шинжилгээ, рН, TDS (нийт ууссан давс), нийт хатуулаг (CaCO3), ууссан хүчилтөрөгч, БХХ, XXX, Ca, Mg, Na, K, SO4, NO2, NO3, NH4-ны агууламж, амт, үнэр, өнгө Тунгаах нуурын ус хашсан далангийн суурийн	Усны тухай хууль 2012.05.17 Усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам- 2015.06.05 А-230/127 MNS 4586:1998. Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага. “Гадаргын усны цэврийн зэргийн ангиллын норм”
2		Эргэлтийн усан сан		2	45,000			
3		Туул голын ус		2	45,000	90,000		

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
							тогтворжилтыг хянах, ус алдагдахаас сэргийлэн хянана.	Уурхайн шүүрлийн усыг “хүрээлэн буй орчин, эрүүл мэндийг хамгаалах аюулгүй байдал.
Хөрсний бохирдлыг хянах								
1	Хөрсний агрохимийн шинжилгээ	Шимт хөрсний овоолгын байршил орчимд	Жилд 2 удаа	2	20,000	530,000	Хөрсний үндсэн химийн болон физик шинж чанар, төлөв байдлын судалгааг хөрсний бүрэн зүсэлт хийж тодорхойлох мөн хүнд металллын бохирдлыг тодорхойлох Хөрсний элэгдэл эвдрэл, гадаргын төрх төлөв байдлын өөрчлөлтийн хэмжилт, судалгаа	Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS5916:2008 “Ариун цэврийн тухай” хууль: 7-р зүйл: 7.4, 7.5 Дээжлэлт хийхдээ MNS: 3297:1991 MNS 3473:1983 MNS 4288:1995 MNS 5850:2008
2	Хөрсний ерөнхий агрохимийн шинжилгээ, хүнд металл	Цэвэр хөрстэй талбай		2	45,000			
3	Хөрсний ерөнхий агрохимийн шинжилгээ, хүнд металл	Баяжуулах хэсгийн орчимд		2	45,000			
4	Хөрсний ерөнхий агрохимийн шинжилгээ, хүнд металл	Дотоод тээврийн зам дагуу		2	45,000			
5	Хөрсний эрүүл ахуй	Уурхайн хотхоны байршилд ажилчдын ашиглаж буй жорлонгийн болон хогийн цэг ойролцоох газар		2	25,000			
6	Хөрсний хүнд металл	Засварын газрын талбайн байршил		2	25,000			

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
		орчимд						
7	Хөрсний хүнд метал, агрохими, эрүүл ахуй	Ажилчдын хотхоны орчинд		2	60,000			
Ургамлан нөмрөг								
1	Ургамлан бүрхэвчийн хэв шинж	Төслийн талбайн орчимд	08 сарын дунд үед 1 удаа		20,000		Ургамлын ургац бүрэн боловсрох хугацаа нь 08 сарын дунд үед байдаг	Байгалийн ургамлын тухай хууль, 1995 он Ургамал хамгаалал. Нэр томъёо, тодорхойлолт MNS 3474 : 2003
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нэг жилийн зардлыг дүн, сая төгрөг						1,120,000		

3.11.1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр агаар

Уурхайн талбайд агаарын шинжилгээний үр дүн Байгаль орчны судалгаа шинжилгээний төв лабораториос одоогоор шинжилгээний хариу нь ирээгүй байна.

3.11.2. Усан орчны хяналт шинжилгээ

Хүснэгт 15. Уурхайн баяжуулах үйлдвэрийн тунаах нуур 2024.10.03-ны байдлаар

№	Үзүүлэлт /Parameters/	ЗДХ /Technical specification/ мг/л	Үрдүн /Test result/
Энхний шинжилгээний үзүүлэлт-Химийн үзүүлэлтээр			
1	pH-Усны орчин /Hydrogen ions, mg/l /	6.0-9.0	7.39
2	Аммони, (NH ^{4*}) MrN/л /Ammonia, mgN/l/	-	81.86
3	Хлорид, Cl', мг/л /Chloride Cl' mg/l /		283.60
4	Сульфат (SO ₄) ² мг/л / Sulfate, mg/l /	-	1403.36
5	Умбуур бодис, мг/л /TSS, mg/L /	<30.0	26630.00
6	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, (XXX), мг/л /COD, mg/l /	<50.0	2332.00
7	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, (БХХ), мг/л /BOD, mg/l /	<20.0	896.92

8	Нитрит (NO ₂), МгN/л / Nitrite, mgN/l /		1.09
9	Нитрат (NO ₃), МгN/л / Nitrate, mgN/l /		5.41
10	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч 1 мл-г	илрэхгүй	Илэрсэн
Энхний шинжилгээний үзүүлэлт -Хүнд металлын бохирдол			
1	Манган, (Mn) мг/л /Manganium, Mn, mg/L/	<0.5	<0.005
2	Никель, (Ni) мг/л /Nickel, Ni, mg/L/	<0.2	<0.0069
3	Зэс, (Cu) мг/л /Copper, Cu mg/L/	<1.0	<0.0042
4	Кадми, (Cd) мг/л /Cadmium, Cdmq/LI	<0.03	<0.0015
5	Кобальт, (Co) мг/л /Cobalt. Co, mg/L /	<0.02	<0.0056
6	Хар тугалга.РЬ мг/л /Lead , Pb mg/L /	<0.1	<0.0002
7	Цайр , (Zn) мг/л /Zinc, Zn, mg/L /	<3.0	<0.0097
8	Нийт хром (Cr) мг/л /Chromium, Cr, mg/L /	<0.3	<0.0045
9	Нийт төмөр (Fe) мг/л /Iron, Fe, mg/L /	<1.0	0.0001
10	Бисмут, (Bi) мг/л /Bismuth. Bi. mg/L/	<0.001	<0.0016
11	Хөнгөнцагаан,(Al),мг/л /Aluminum, Al, mg/L /	<0.5	0.056
12	Лити , (Li) мг/л /Lithium, Li, mg/L/	-	0.0042
13	Бари, (Ba) мг/л /Barium, Ba. mg/L/	<1.5	0.0068
14	Мөнгө, (Ag) мг/л /Silver, S, mg/L /	-	<0.0041
15	Бор, (B) мг/л / Bor. B. mg/L/	<0.5	0.0033
16	Галли , (Ga) мг/л /Gallium, Ga, mg/L /	-	<0.0023
17	Стронци , (Sr) мг/л /Strontium. Sr. mg/L/	<2.0	0.0013
18	Инди, (In) мг/л /Indium, In. mg/L/	-	<0.0042
19	Талли, Та мг/л / Tallium, Tl mg/L /	*	<0.0029
20	Ванади, V мг/л /Vanadium. V mg/L/	<0.1	<0.005
Шинжилгээний 2-р дүн мэдээ-усны ерөнхий химийн шинжилгээ			
№	Үзүүлэлт /Parameters/	ЗДХ /Technical specification/ мг/л	Үрдүн /Test result/
1	рН	6-9	6.57
2	Чөлөөт хлор, Cl _{чвл}	1.0	<0.10
3	Хуурай үлдэгдэл, TDS	1000	876.0
4	Умбуур бодис, TSS	30	33.00
5	Исэлдэх чадвар /KMnO ₄ /	20	40.00
6	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, COD	50	275.5
7	Биологийн хэрэгцээт хүчилтөрөгч, BOD	20	102.8
Шинжилгээний 2-р дүн мэдээ-Хүнд металлын задлан шинжилгээний дүн мэдээ			

1	Хүхэргүстөрөгч, H ₂ S	0.5	<0.10
2	Хром, Cr (VI)	0.01	<0.05
3	Хөнгөнцагаан, Al	0.5	0.87
4	Мышьяк, As	0.01	<0.01
5	Бари, Ba	1.5	0.02
6	Берелли, Be	0.001	<0.001
7	Кобальт, Co	0.02	0.002
8	Кадми, Cd	0.03	<0.005
9	Хром, Cr	0.3	<0.005
10	Зэс, Cu	1.0	<0.02
11	Төмөр, Fe	1.0	0.14
12	Марганец, Mn	0.5	0.09
13	Молибден, Mo	0.5	<0.005
14	Никель, Ni	0.2	0.008
15	Фосфор, P	1.5	0.51
16	Хартугалга, Pb	0.1	<0.01
17	Сурьма, Sb	0.05	<0.01
18	Селен, Se	0.02	<0.01
19	Стронци, Sr	2.0	0.76
20	Уран, U	<0.10	0.05
21	Цайр, Zn	0.07	3.0
22	Цианид, C ⁻	<0.002	0.050
23	Цианид, CN _{free}	<0.002	0.050
24	Мөнгөн ус, Hg	<0.001	0.005

Усны дээжлэлтийн үзүүлэлт:

Булган аймаг, Бүрэгхангай сум, 3-р баг, Бохирын нуур 48°14'35.6", 104°20'11.2" солбицолоос авсан дээжинд Монгол улсын Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг-Усны газрын лабораториор шинжилгээ хийлгэж үзэхэд хүлцэх хэмжээнээс давсан бохирдолын зүйл уурхайн угаан баяжуулах талбайгаас эхний шинжилгээний үр дүнгээс үзэхэд биохимийн болон химийн хэрэгцээт хүчилтөрөгч хэт өндөр умбуур бодис илэрсэн гэж гарж байна. Энэ нь угаан баяжуулах үйлдвэрийн угааж буй шавар, элс дайрганаас гарсан шороон бохирдолоос шууд илэрсэн үзүүлэлт юм. Харин хүнд металлын бохирдлын хувьд бисмут, хөнгөнцагааны бохирдол илэрсэн ба энэ нь төмрийн хийц үйлдвэрлэхэд ашигладаг 2 төрлийн бодис бөгөөд скруберыг төмрөөр хийж буй тул энэхүү бохирдол угаагдсан зэвтэй холбоотой байж болно. Харин хөнгөн цагааны бохирдлын хувьд байгаль дээр байдаг хүнд металлын төрөл зүйл бөгөөд олборлолтын шатанд үүсч бий болсон гэж таамаглаж байна.



Хүснэгт 16. Уурхайн ахуйн бохир усны буюу цэвэрлэх байгууламжийн саарал усны шинжилгээ-эхний шинжилгээ

№	Үзүүлэлт /Parameters/	Шинжлэх аргын стандарт /Test method/	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ /Technical specification/	Үрдүн / Test result/
1	pH-Усны орчин /Hydrogen ions, mg/l /	MNS ISO 10523-2001	6.0-9.0	7.64
2	Аммони, (NH ^{4*}) МгN/л /Ammonia, mgN/l/	MNS ISO 4428:1997		25.22
3	Хлорид, Cl ⁻ , мг/л /Chloride Cl ⁻ mg/l /	MNS ISO 9297: 2007	*	134.71
4	Сульфат (SO ₄) ² мг/л / Sulfate, mg/l /	MNS ISO 6271:2011		138.32
5	Умбуур бодис, мг/л /TSS, mg/L /	MNS ISO 11923:2001	<30.0	339.00
6	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, (XXX), мг/л /COD, mg/l /	ХТЛ-СА3-4/02	<50.0	1042.50
7	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, (БХХ), мг/л /BOD, mg/l /	ХТЛ-СА3-4/01	<20.0	400.96
8	Нитрит (NO ₂), мЕN/л / Nitrite, mgN/l /	MNS ISO 4431:2005	-	0.01
9	Нитрат (NO ₃), МгN/л / Nitrate, mgN/l /	MNS ISO 7890-3:2001	-	1.79
10	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч 1 мл-г	MNS 5668:2006	илрэхгүй	Илрээгүй

Хүснэгт 17. Уурхайн ахуйн бохир усны буюу цэвэрлэх байгууламжийн саарал усны шинжилгээ-2-р шинжилгээ

№	ҮЗҮҮЛЭЛТ	СТАНДАРТ АРГА	НЭГЖ	ЗӨВШӨӨРӨГДӨХ ДЭЭД ХЭМЖЭЭ MNS 0900:2018	ШИНЖИЛГЭЭНИ Й ДҮН
Эрүүл ахуйн үзүүлэлт					
1	Бактерийн ерөнхий тоо	MNS ISO 6222:1998	1 МЛ-Д	100	2

2	Халуунд гэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн ТОО	MNS ISO 9308-1:1998	100 мл-д	илрэхгүй	илрээгүй
3	Колиформ гэдэсний булгийн НЯНГИЙН ТОО	MNS ISO 9308-1:1998	100мл-д	илрэхгүй	илрээгүй
4	Гэдэсний бүдгийн эмгэг төрөгч ияя	MNS ISO 19250:2017	25 мл-д	илрэхгүй	илрээгүй
5	Clostridium perfringens	MNS ISO 6461-2:1998	100 мл-д	илрэхгүй	илрээгүй
Химийн шинжилгээ					
1	pH			6-9	6.57
2	Чөлөөт хлор, $Cl_{чвл}$			1.0	<0.10
3	Хуурай үлдэгдэл, TDS			1000	876.0
4	Умбуур бодис, TSS			30	33.00
5	Исэлдэх чадвар / $KMnO_4$ /			20	40.00
6	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, COD			50	275.5
